

Гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг дээшлүүлэх зарим арга зам

Some Ways to Increase the Effectiveness of Performance Auditing

Д. Авирмэд¹

Хураангуй

Төрийн аудит нь төсвийн хөрөнгийг хуулийн дагуу, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөж, хуваарилж, ашиглаж, зарцуулж байгаа эсэхийг хянахад чиглэгддэг. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үр дүн нь олон нийт, иргэдэд зориулагддаг. Иймд энэхүү судалгааны ажлын хүрээнд төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар иргэдээс судалгаа авах замаар гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг тодорхойлж, цаашид сайжруулах арга замыг эрэлхийлсэн болно. Уг асуудлыг Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын жишээн дээр судаллаа. Мөн төсөвт байгууллагуудын нягтлан бодогч, төсөл хариуцсан мэргэжилтэн зэрэг удирдах албан тушаалтнуудаас судалгаа авч гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг сайжруулах арга замуудыг тодорхойлоход ашигласан.

Түлхүүр үгс: төрийн аудит, гүйцэтгэлийн аудит, үр дүн, үр нөлөө, үр ашиг

Abstract

Public audit is aimed at monitoring whether budget funds are planned, allocated, used and spent in accordance with the law, economically, efficiently and effectively. The activities of government organizations and the results of ongoing projects and programs are intended for the public and citizens. Therefore, in the framework of this study, the effectiveness of performance audits was identified by seeking feedback from citizens on the implementation and results of projects and programs, and ways to further improve were sought. This issue was studied on the example of the Road Policy Implementation Coordination Department of the Ministry of Road and Transport Development. It also used referendum from senior executives, such as accountants and project managers, to determine the effectiveness of performance audits.

Keywords: public auditing, performance audit, result, effectiveness, efficiency

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим, Доктор (Ph.D)
E-mail: avirmedd@num.edu.mn

Удиртгал

Төрийн аудитын дээд байгууллага болох Үндэсний аудитын газраас жил бүр санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн, болон нийцлийн аудитыг гүйцэтгэх ба үндсэн зорилго нь зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага, зөвлөмж өгч хэрэгжилтийг үнэлснээр төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн сахилга батыг сайжруулах явдал юм. Гэвч өмнөх онд өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн зөрчлийг арилгахгүй байх, дахин зөрчил гарахаас урьдчилан сэргийлж чадалгүй дараа ондоо дахин ижил албан шаардлага, зөвлөмж авах үзэгдэл цөөнгүй тохиолдож байна.

Тухайлбал, 2018 онд Макро түвшний судалгаа, зах зээлийн гадаад, дотоод хүчин зүйлсийн үндэслэлийг бодитой тооцоолж, тусгаагүйгээс Монгол Улсын төсвийн тухай хуулийг батлахдаа өмнө баталсан Төсвийн хүрээний мэдэгдэл (ТХМ)-ийг өөрчилсөн байсныг аудитаар илрүүлэн зөвлөмж өгсөн ч 2019 онд дээрх зөрчлөөс үүдэн батлагдсан ТХМ-ийн үзүүлэлтийг төсвийн төлөвлөлтөд 3, төсвийн гүйцэтгэлд 1 үзүүлэлтээр тус тус хангаагүй байв. Мөн зарим Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-дын дотоод хяналтын бүтэц, орон тоо, зохион байгуулалт сул байгаагаас хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг 2017 онд илрүүлсэн боловч 2018 онд зарим ТЕЗ-д өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төвлөрүүлээгүйтэй холбоотойгоор Улсын төсвийн эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал төлөвлөснөөс 8.5 тэрбум төгрөг

буюу 3.3 хувиар хэтэрсэн; 2019 онд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх төлөвлөлт, гүйцэтгэл нь шийдвэр гаргалтад ашиглах ач холбогдол багатай, үр дүнгийн шалгуур үзүүлэлт тохиромжгүй, зарим хүрэх үр дүнгийн хэрэгжих боломжтой хугацааг үндэслэлтэй тооцоолоогүй, өртөг тооцоололт хангалтгүй байсан² гэж дүгнэжээ.

Ийнхүү аудитын үйл ажиллагааны үр дүнд зөрчил дутагдал арилахгүй, хэд хэдэн он дамжин давтагдсаар байгаа нь төрийн аудитын үр нөлөө хангалттай сайн биш байгааг илтгэнэ. Төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн үр дүнтэй, үр ашигтай байдал, цаашлаад төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулахад олон хүчин зүйл нөлөөлөх ба тэдгээрийн нэг нь төрийн аудит, тэр дундаас гүйцэтгэлийн аудит юм. Гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг дээшлүүлэх замаар аливаа зөрчлийг илрүүлэх, арилгах, давтан гаргахгүй байх, цаашлаад төсвийн сахилга хариуцлага, төсөл хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх боломж бүрдэнэ.

Төрийн аудитын өнөөгийн байдал

Аудитын хөгжлийн хандлагыг дэлхийн улс орнуудын хэмжээнд авч үзвэл аудит нь тоон үзүүлэлтээс чанарт илүү анхаарч, агуулгын хувьд нотлох үйл ажиллагаанаас баталгаа өгөхөд илүүтэй чиглэгдэх болсон билээ.

Монгол Улс Төрийн аудитын Вестминстерийн тогтолцоо буюу ерөнхий аудиторын тогтолцооны загвар хуулийг үндэс болгон Улсын Их Хурлаас Төрийн аудитын тухай хуулийг 2003 оны 1 сард

² Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан (2017, 2018, 2019)

³ Үндэсний аудитын газар “Түүхэн замнал”

батлан, мөрдүүлж эхэлсэн³. Төрийн аудитыг хэрэгжүүлж буй дээд байгууллага бол Үндэсний аудитын газар (ҮАГ) бөгөөд төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитыг гүйцэтгэнэ. Аудит хийх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

- Шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулахыг санхүүгийн тайлангийн аудит гэнэ.
- Шалгагдагч этгээдийн бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үйл явц, үр дүн, гүйцэтгэлд аудит хийхийг гүйцэтгэлийн аудит гэнэ.
- Шалгагдагч этгээдийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд аудит хийхийг нийцлийн аудит гэнэ.

Практикт гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын журмыг боловсруулан хэрэглэж байгаа нь аудитын хөгжлийн ерөнхий хандлагад нийцсэн бодит алхмуудыг хийж эхлээд байгаагийн нэг илрэл юм.

Төрийн аудитын үйл ажиллагааг тоон

үзүүлэлтээр дүгнэх зорилгоор сүүлийн жилүүдэд гүйцэтгэсэн аудитын тоог Хүснэгт 1-т харууллаа.

Сүүлийн 3 жилд нийт хийгдсэн аудитын тоо жил бүр өсч байгаа боловч гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тоо тогтмол буурчээ. Гүйцэтгэлийн аудит нь төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд чиглэдэг тул төсөл, хөтөлбөрт зарцуулж буй төсвийн хөрөнгийн үр дүнтэй, үр ашигтай зарцуулж байгаа эсэхэд тавьж буй хяналт тооны хувьд хангалттай сайн биш байж болохыг энэ үзүүлэлт харуулж байна.

Энэхүү тоон үзүүлэлт гүйцэтгэлийн аудит үр дүнтэй, үр нөлөөтэй эсэх талаар бүрэн үнэлэлт өгч чадахгүй юм. Иймд аудитын чанарын үзүүлэлт талаас нь үнэлэлт өгөх шаардлагатай гэж үзсэнээр гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагааны үр дүнгийн зарим судалгааг хийсэн болно.


Гүйцэтгэлийн аудитын хийгдсэн тоо 2010, 2013, 2017 онуудад тодорхой хэмжээгээр өссөн боловч ерөнхий утгаараа тасралтгүй буурсан үзүүлэлттэй байна (Зураг 1). Төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хийгдэж буй томоохон бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн тоо, санхүүжилтийн дүн нэмэгдсээр байхад гүйцэтгэлийн аудитын тоо буурч байгаа нь төсвийн хөрөнгийн үр дүнгүй, үрэлгэн зарцуулалт үүсэх нэг нөхцөл байж болох юм.

Хүснэгт 1. Төрийн аудит гүйцэтгэсэн тоо, төрлөөр

№	Аудитын төрөл	2017		2018		2019	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Санхүүгийн тайлангийн	3,179	89.4%	3,806	92.7%	3,958	93.5%
2	Гүйцэтгэлийн	210	5.9%	201	4.9%	165	3.9%
3	Нийцлийн	167	4.7%	97	2.4%	108	2.6%
Нийт дүн		3,556	100%	4,104	100%	4,231	100%

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан, 2017-2019

Зураг 1. Хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тоо



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Зураг 2. Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүн



Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө ямар түвшинд байгааг үнэлэн, сайжруулах арга замыг тодорхойлох зорилгоор төсөвт байгууллагын 322 нягтлан бодогч, эдийн засагч, удирдах ажилтнуудыг хамруулан судалгаа хийсэн. Нийт судалгаанд хамрагдагсдын 57% нь гүйцэтгэлийн аудитын талаар онолын болон арга зүйн хангалттай мэдлэг ойлголттой байсан бол 43% нь хангалтгүй гэж хариулжээ. Мөн гүйцэтгэлийн аудит хийгдэх шаардлагыг доорх байдлаар тодорхойлсон байна.

- Төсвийн хөрөнгийн үр ашигт байдлыг дээшлүүлэхийн тулд (87.5%);
- Зөрчил илрүүлж, акт, торгууль тавихын тулд (25%);
- Үйл ажиллагааны үр дүнг үнэлж, зөвлөмж өгөхийн тулд (68.8%);
- Төрийн үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулахын тулд (56.3%).

Гүйцэтгэлийн аудит хийгдсэн төсөл хөтөлбөрүүдийн үр дүн, үр өгөөж, нийгэмд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох зорилготой асуулгын судалгааны дүнг Зураг 2-т харууллаа.

Төсөл хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээнд оролцдог байгууллагын албан тушаалтан, ажилтнуудын үнэлж байгаагаар төсөл хөтөлбөрүүд төдийлөн хангалттай үр дүнтэй байж чаддаггүй байна.

Түүнчлэн хариуцлага, итгэлцэл, харилцан нөлөөлөл хүндрэл бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд захиалагч, гүйцэтгэгч, аудитын байгууллагын үйл ажиллагаа, ашиг сонирхол уялдаатай байж чаддаг эсэх, ямар хүндрэл үүсдэгийг асуухад:

- Төсөл хөтөлбөр үндэслэлгүй байх нь элбэг,

- Нийгэмд зайлшгүй шаардлагатай зүйлсдээ анхаарч чадахгүй байна,
- Албан тушаалтнуудын эрх үүргийнхээ дагуу шударгаар ажлаа хийхэд бэрхшээлтэй зүйл багагүй тохиолддог,
- Өөрөө хүссэн ч, хүсээгүй ч даалгавар өгөгдсөн үед зааврын дагуу ажиллахад хүрдэг,
- Аудит, шалгалтын байгууллагын хяналт шалгалт төслийн аль ч үе шатанд нөлөөлж чадахгүй байна,
- Аудитын байгууллага, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, төслийн захиалагч талуудын үйл ажиллагаа, ашиг сонирхол уялдаагүй, маш их зөрүүтэй байдаг зэрэг хариултыг өгч байв.

Гүйцэтгэлийн аудитын давтамжийг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдын ажилладаг байгууллагад хамгийн сүүлд хэзээ аудит хийгдсэнийг асуухад:

Зураг 3. Хамгийн сүүлд гүйцэтгэлийн аудит хийгдсэн хугацаа



Эндээс харахад сүүлийн 1-3 жилүүдэд гүйцэтгэлийн аудит хийгдсэн тоо хамгийн их байгаа бөгөөд аудитын давтамж тийм ч хол биш байна гэж дүгнэлээ. Энэ нь ҮАГ-ын салбар байгууллагууд төлөвлөгөөнд тусгасан гүйцэтгэлийн аудитыг хугацааны хувьд хойшлуулалгүй хийж гүйцэтгэдэг болохыг илтгэнэ.

Гүйцэтгэлийн аудитын чанарыг үнэлэх зорилгоор үндэслэлтэй, бодитой байдлын талаар асуухад:

Зураг 4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн үндэслэлтэй, бодитой байдал



Хэдийгээр илрүүлсэн алдаа зөрчил хүлээн зөвшөөрөхүйц үндэслэлтэй, бодитой байдаг боловч 37.5% нь бодит байдлыг харгалзан үзээгүй илрүүлэлт, дүгнэлт байдаг гэж хариулсан байгаагаас үзэхэд аудитын үйл ажиллагааг бодит нөхцөлд уялдуулах шаардлага үүсээд байна.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн санал, зөвлөмжийг 80% нь хэрэгжүүлдэг гэж хариулсан бол 20% нь хэрэгжүүлдэггүй

гэж хариулжээ. Мөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй нь доорх шалтгаантай байна (давхардсан тоогоор).

- Бодит байдалд хэрэгжих боломж хязгаарлагдмал байдаг (77.8%),
- Зөвлөмж ойлгомжгүй, тодорхой бус байдаг (44.3%),
- Аудитаар өгсөн зөвлөмж нь бусад байгууллагын зөвлөмж, хууль эрх зүйн зарим заалттай зөрчилддөг (44.4%),
- Өмнөх аудиторын зөвлөмжтэй давтагддаг, зөрчилддөг (11.1%),
- Зарим аудиторын мэдлэг, ур чадвар хангалтгүй байдаг (11.1%),
- Улс төрийн шинжтэй, ажлын үр дүнг хэт сөргөөр үнэлж харлуулах зорилготой байдаг (11.1%),
- Зарим зөвлөмж нь төслийн онцлогийг харгалзан үзээгүй байдаг (11.1%).

Гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буйг эрх бүхий байгууллагаас хянадаг эсэх тухай асуухад 56.3% нь тийм, 43.8% нь үгүй гэж хариулсан бөгөөд аудитын мөрөөр хийгдэж буй ажил нь үр дүнтэй хэрэгжиж чаддаг эсэх тухай асуухад 18.8% нь Чаддаг, 50% нь Зарим талаар чаддаг, 31.3% нь Чаддаггүй гэж хариулжээ. Эндээс, гүйцэтгэлийн аудитын мөрөөр хийгдэж буй ажлууд хангалтгүй бөгөөд үр дүн төдийлөн сайн биш харагдаж байна. Мөн байгууллагын зүгээс хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явцын байдалд 25% нь тогтмол мониторинг хийдэг, 62.5% нь хааяа хийдэг бол 12.5% нь огт хийдэггүй байна.

Түүнчлэн гүйцэтгэлийн аудитын практикт тулгамддаг асуудлуудыг доорх байдлаар тодорхойлсон байна.

- Аудитын хугацаа давчуу байдаг (50%),
- Аудиторууд солигддог (25%),
- Өмнөх аудиттай залгамж холбоогүй ажилладаг (37.5%),
- Стандарт, дүрэм, журам тодорхой бус байдаг (31.3%),
- Стандарт, дүрэм, журмаа баримталдаггүй (18.8%),
- Хэт субъектив байдлаар ханддаг (31.3%),
- Шалгуур тодорхойгүй байдаг (43.8%).

Ийнхүү төсвийн байгууллагын тодорхой эрх бүхий ажилтнууд гүйцэтгэлийн аудитын үр дүн, үр нөлөө тийм ч хангалттай биш гэж дүгнэж байна.

Монгол Улс хөтөлбөрт суурилсан төсвийн удирдлагыг хэрэгжүүлдэг бөгөөд “Төсвийн тухай” хуульд “Төсвийн зарлага гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг ойлгоно”⁴, “Хөтөлбөр гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг ойлгоно”⁵ хэмээн тодорхойлсон байдаг. Иймд төсвийн зарцуулалтын үр дүн хөтөлбөрийн хэрэгжилтээр үнэлэгдэнэ.

Төсвийн зарцуулалт үр дүнтэй, үр ашигтай, үр нөлөөтэй байж чадаж байгаа эсэхийг ҮАГ-ын тайлан, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын тайлан, жил бүрийн төсвийн тухай хууль түүний хэрэгжилтийн тайлан зэрэг олон мэдээлэл, эх сурвалжид үндэслэн үнэлэлт дүгнэлт өгч ирсэн.

⁴ “Төсвийн тухай” хууль, 4.1.10

⁵ “Төсвийн тухай” хууль, 4.1.16

Харин нийгэм, ард иргэдэд чиглэсэн эдгээр төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг эцсийн хэрэглэгчээр үнэлүүлэх, тэдний санаа бодлыг төсөл, хөтөлбөрт тусгах талаар анхаарч судлах шаардлагатай гэж үзсэний үндсэн дээр бид судалгаандаа улсын төсвийн болон гадаадын хөрөнгө оруулалтаар томоохон бүтээн байгуулалт хийдэг салбаруудын нэг болох авто замын салбарыг сонгон авч, хэрэглэгчдийн судалгаа явуулсан юм.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцооны мөн чанар нь төр эдийн засагт зохицуулагчийн үүргийг гүйцэтгэдэг явдал юм. Төрийн оролцоо зайлшгүй болохыг тодорхойлдог дэд бүтэц, батлан хамгаалах, боловсрол, эрүүл мэнд зэрэг стратегийн ач холбогдол бүхий салбарууд гэж бий. Үүний нэг нь зам тээвэр, дэд

бүтцийн салбар билээ.


Бид судалгааны объект болгон Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрыг сонгож авсан.

Монгол Улсад тэмээн жин, морин өртөө зэрэг ердийн хөсөг тээврийг халж ачаа, зорчигч тээвэрлэх механикжсан тээврийн хэрэгслээс бүрдсэн шинэ салбар анх 1925 онд сууриа тавьж, орчин цагийн авто тээврийн салбарын эхлэл болсон. Өдгөө Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ) нь дотроо 15 газар, хэлтэс, 128 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

ЗТХЯ-ны нэгж хэсгүүд доорх төрийн үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Авто зам,

Зураг 5. Монгол Улсын ЗТХЯ-ны зохион байгуулалтын бүтэц



Эх сурвалж: ЗТХЯ-ны цахим хуудас, “Бүтэц, зохион байгуулалт” <https://mrt.d.gov.mn>

- Авто тээвэр,
- Төмөр зам, далайн тээвэр,
- Агаарын тээвэр.

ЗТХЯ-наас жил бүр үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрт жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр ханган ажилладаг. Дээрх ажлыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хариуцан явуулдаг бөгөөд уг дотоод хяналт нь гүйцэтгэлийг тодорхой үнэлж чаддаг ч бодлого, хөтөлбөр, зорилго, зорилтууд зөв зүйтэй, оновчтой бөгөөд тохиромжтой эсэх, нөөцийг олж авах, ашиглахдаа арвилан хэмнэлттэй, үр ашигтай байгаа эсэхийг тодорхойлох, хөтөлбөр, түүний бүрэлдэхүүн хэсгийн үр нөлөөг үнэлэх, хангалттай үр дүнд хүрэхэд саад болж буй хүчин зүйлсийг тогтоох, тухайн хөтөлбөр бусад хөтөлбөрийг орлон нөхөж, түүнтэй давхардаж эсвэл зөрчилдөж буй эсэхийг тогтоох зэрэг гүйцэтгэлийн аудитаар шалгах зүйлсийг орлох боломжгүй юм.

Яамны газрууд тус яамны Төрийн нарийн бичгийн даргын шууд удирдлагад

харъяалагдах ба Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (АЗБХЗГ) нь авто замын үйлчилгээг хариуцан ажилладаг. АЗБХГ-т замын ашиглалт, засварын хэлтэс ажиллана.

Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг шалгахад яамны 2019 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 192 арга хэмжээний 135 нь хэрэгжсэн, 37 нь 70%-ийн хэрэгжилттэй, 14 нь 30%-ийн хэрэгжилттэй, 1 арга хэмжээ хэрэгжээгүй, 5 арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон тул үнэлээгүй, хэрэгжилт 88.3%-тай байна.

Нийт үйл ажиллагааны хөтөлбөрийн 40.5% нь бүрэн хэрэгжсэн бөгөөд 13.5% нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн хэрэгжилттэй байна. Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30%-ийн гүйцэтгэлтэй хөтөлбөр нийт хөтөлбөрийн 6.3%-ийг, тодорхой шалтгааны улмаас үнэлэх боломжгүй хөтөлбөр 39.7%-ийг эзэлж байна.

Хүснэгт 2. Яамны 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	100	70	40	0	Үнэлэх боломжгүй	Хувь
1	АЗБХЗГ	68	24	7	4	-	38	87.1%
2	АТБХЗГ	13	6	4	2	-	1	80.0%
3	ТЗДТБХЗГ	21	11	2	1	-	7	91.7%
4	АТБХЗХ	26	13	5	1	-	7	88.9%
5	БТГ	13	9	3	1	-	3	92.5%
6	“МТЗ” ТӨХК	5	-	1	-	-	4	70.0%
7	“УБТЗ” ХНН	3	3	-	-	-	-	100.0%
8	“Нортерн рейлвейс” ХХК	1	-	-	-	-	1	-
9	Далайн захиргаа	4	3	-	-	-	1	100.0%
Нийт		126	51	17	8	-	50	87.0%

Эх сурвалж: “Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товч тайлан”, 5-р тал

Нийт үнэлэх боломжгүй хөтөлбөрүүдийн 76% нь АЗБХЗГ-ын үйл ажиллагаанд хамаарч байгааг дурьджээ.

Судалгаа

2019 онд Авто замын салбарт Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулалтын чиглэлээр 72 төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна. Эдгээр төсөл хөтөлбөрүүдийг бүс нутгаар нь ангилан авч үзвэл Баруун бүс 18, Хангайн бүс 9, Төвийн бүс 12, Зүүн бүс 8, Улаанбаатар хот 25 байна.

Дээрх төсөл хөтөлбөрийн хэрэгжилт практикт хэрхэн биеллээ олж байгааг тодорхойлох зорилгоор 1,440 тээврийн хэрэгсэл эзэмшигч, жолоочдоос Google form ашиглан судалгаа авсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 25% нь Баруун бүс, 12.5% нь Хангайн бүс, 16.7% нь Төвийн бүс, 11.1% нь Зүүн бүс, 34.7% нь Улаанбаатар хотын иргэд байв.


Судалгаанд оролцогчдын 64.1% нь 5 хүртэлх жил, 8.7% нь 5-10 жил, 9.7% нь 10-15 жил, 17.5% нь 15-аас дээш жил тээврийн хэрэгсэл жолоодож байна.

АЗБХГ-ын хариуцах үндсэн 2 чиглэл болох замын бүтээн байгуулалт, авто замын засвар арчилгааны байдлыг үнэлэх зорилгоор асуусан асуултад хэрхэн хариулсныг авч үзвэл:

Замын бүтээн байгуулалтын ажил хэр үр дүнтэй байна вэ гэсэн асуултад 1-ээс 5 оноогоор үнэлгээ өгсөн. Тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн 251 хүн 1 оноо, 289 хүн 2 оноо, 457 хүн 3 оноо, 313 хүн 4 оноо, 130 хүн 5 оноо тус тус өгсөн байна. Үр дүнг тооцвол, 1-ээс 5 оноогоор үнэлэхэд 2.8 буюу хангалтгүй гэж үнэлжээ.

Замын засвар, арчилгаа үйлчилгээний ажлын чанарыг мөн 1-ээс 5 оноогоор дээрх зарчмаар үнэлэхэд 2.7 буюу мөн л хангалтгүй гэж үнэлсэн байна.

Зураг 6. Замын хөдөлгөөний ачаалал ба гарсан өөрчлөлт



Авто замын бүтээн байгуулалт, арчилгаа үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэснээр замын хөдөлгөөний ачаалал буурч, зорчих хугацааг багасгах, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтлийг бууруулах, түлш зарцуулалтыг бууруулах зэрэг эдийн засаг, нийгмийн шууд болон шууд бус олон талын сайн үр нөлөө, үр дагаврыг бий болгоно гэж үздэг. Авто замын салбарт оруулсан төсвийн хөрөнгө оруулалтын иргэдэд тусах шууд үр нөлөө хэрхэн илэрч буйг тодорхойлох зорилгоор асуусан асуултад судалгаанд оролцогчид хэрхэн хариулсныг Зураг 6-д үзүүлэв.

Асуулгад сүүлийн 5 жилд гарсан өөрчлөлтийг үнэлэхээр тусгаж өгсөн бөгөөд судалгаанаас харахад энэ хугацаанд замын ачаалал асар ихээр өссөн гэжээ. Энэ нь зам барих, арчлах төсөл, хөтөлбөрөөс шууд хамаарсан эсэхийг асуугаагүй тул автомашины тоо өссөн, хүн амын суурьшил нягтрал зэрэг олон хүчин зүйлүүдээс шалтгаалсан байж


Зураг 7. Замын хөдөлгөөнд оролцоход зарцуулдаг хугацаанд гарсан өөрчлөлт




болно.

Замын хөдөлгөөнд зарцуулах хугацаа ихэссэн байгаа (Зураг 7) нь замын ачаалал нэмэгдсэнтэй шууд холбоотой гэж үзэж

Зураг 8. Тээврийн хэрэгслийн эвдрэл, гэмтэл ба түүнд гарсан өөрчлөлт



Зураг 9. Түлшний зарцуулалт ба түүнд гарсан өөрчлөлт



байна.

Тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл нэлээд их байдаг бөгөөд сүүлийн 5 жилийн байдлаар буураагүй байна (Зураг 8). Энэ нь авто замын салбарт оруулсан хөрөнгө оруулалт иргэддээ дэмжлэг болж чадахгүй, тэдний зардлыг бууруулахгүй байна гэсэн үг юм.

Түлшний зарцуулалт их байдаг, сүүлийн жилүүдэд илүү нэмэгдсэн нь (Зураг 9) замын ачааллаас гадна эвдрэл гэмтэл, чанар байдлаас шалтгаалдаг гэж үзэж байна.

Тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн энэ салбарт оруулж буй хөрөнгө оруулалтаас хүсэж буй хүлээлт ямар байсныг тодруулахад дараахь байдлаар хариулсан.

Зам гүүр барих ажил нь доорх ач холбогдолтой (олон сонголттой).

- Хөдөлгөөний ачаалал бууруулах (76.2%),

- Цаг хугацаа, зардал хэмнэх (53.3%),
- Зам тээврийн, осол зөрчлийг бууруулах (41%),
- Тээврийн хэрэгслийн насжилтыг уртасгах (30.5%).

Замын засвар, арчилгаа үйлчилгээг сайжруулах нь доорх ач холбогдолтой (олон сонголттой).

- Хөдөлгөөний ачаалал бууруулах (45.6%),
- Цаг хугацаа, зардал хэмнэх (43.7%),
- Зам тээврийн, осол зөрчлийг бууруулах (76.7%),
- Тээврийн хэрэгслийн насжилтыг уртасгах (62.1%).

Ийнхүү хэрэглэгчдийн хүлээлт ба төсөл хөтөлбөрийн хэрэглэгчдэд тусч буй бодит үр дүнгийн хооронд асар их зөрүүтэй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Дээрх тоон мэдээллүүдийг нэгтгэн үзвэл

замын хөдөлгөөний ачаалал маш их, зарцуулах хугацаа их, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл, түлшний зарцуулалт өндөр байгаа бөгөөд сүүлийн 5 жилд төдийлөн эерэг өөрчлөлт гараагүй байгаа нь энэ салбарт хийгдсэн төсөл, хөтөлбөрүүд иргэдэд шууд байдлаар үр дүнгээ өгч чадаагүйг харуулж байна.

Нийгмийн асуудал олон хүчин зүйлээс хамаарч байдаг учраас нийгмийн сайн сайхны төлөө зарцуулж буй төсвийн болон бусад эх үүсвэрээс бий болж буй хөрөнгө оруулалтын эцсийн ач холбогдлыг зөвхөн тоон үзүүлэлтээр илэрхийлэх боломжгүй байдаг нь төсвийн салбарын онцлог юм. Энд үр дүн, үр ашиг, үр нөлөө гэсэн чанарын үзүүлэлтүүдээр хэмжиж, үнэлэх хандлага дэлхийн олон улс орнуудад түгээмэл байдаг.

АЗБХЗГ-аас замын бүтээн байгуулалтын ажил, засвар, арчилгаа үйлчилгээг сайжруулах чиглэлээр олон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлжээ. Эдгээр ажлуудын үр дүн, үр ашиг, үр нөлөө ямар байгааг тодорхойлох зорилготой асуултад хариулсан байдлыг авч үзье (Зураг 10).


Замын бүтээн байгуулалтын ажил болон

замын засвар, арчилгаа үйлчилгээ боломжит хамгийн богино хугацаанд бага зардлаар чанарын шаардлага хангахуйц (үр өгөөжтэй) байж чадахгүй байна, төсөл, хөтөлбөрийн үндсэн зорилго, хэрэглэгчдийн хүлээлтэд хүрэхгүй (үр дүнтэй байж чадахгүй) байна, харин нийгэмд тодорхой үр нөлөө бий болгож байна гэж судалгаанд оролцогчид үзжээ (Зураг 11). Энэ нь Зам тээврийн чиг үүрэг бүхий яам, АЗБХЗГ-ын үүрэг нийгэмд зайлшгүй болохыг илэрхийлсэн үр дүн байлаа.


Харин хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй байгаа нь судалгааны үр дүнд батлагсан гэж бид үзэж байна. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнтэй, үр ашигтай байлгахад чиглэсэн төрийн хяналтын тогтолцоо Монгол Улсад үйлчилж байгаа бөгөөд тэр нь төрийн аудит, тухайлж дурьдвал гүйцэтгэлийн аудит юм.

Монгол Улс Төрийн хяналтын тогтолцооны эртний уламжлалтай. Дэлхий нийтээр хяналт тооноос чанарт чиглэх болж, аудитын олон төрөл хэлбэрүүдийг

Зураг 10. Зам гүүр барих ажлын үр дүн, үр ашиг, үр нөлөө



Зураг 11. Замын засвар, арчилгаа үйлчилгээний үр дүн



хөгжүүлэн үр дүнтэй хэрэглэх болсны нэг нь гүйцэтгэлийн аудит юм. Манай практикт гүйцэтгэлийн аудит шинэ тутам хөгжиж байгаа бөгөөд хууль эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн, аудиторуудыг бэлтгэх, давтан сургах тогтолцоо бий болсон, арга зүй, аргачлалыг тодорхой хэмжээнд боловсруулан хэрэглэж байгаа зэрэг бодит алхмуудыг хийж ирсэн. Гэвч нийгмийн асуудал олон талтай, төрийн үүрэг хариуцлага асар өндөр, улс орны хөгжлийн түвшин харилцан адилгүй зэрэг олон хүчин зүйлүүдээс хамаарч сайжруулах, боловсронгуй болгох шаардлагатай зүйлүүд багагүй байсаар байна.

Тухайлбал, ЗТХЯ, АЗБХЗГ-ын үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт 2012-2019 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангуудаас харахад өмнөх аудитаар илрүүлсэн зөрчил, дутагдал дахин давтагдсаар байна. Эдгээрээс дурьдвал:

- Төсөл, хөтөлбөрийн Техник, эдийн засгийн үндэслэл хангалтгүй, судалгаа шинжилгээ үнэн зөв, бүрэн гүйцэд хийгдээгүй, бэлтгэл ажил (газар чөлөөлөлт, зураг төсөв, нөөцийн

үнэлгээ) хангалтгүй байдлаас үүдэн төсөл арга хэмжээ нэмэлт санхүүжилт шаардах, хэрэгжилт зогсох;

- Үйл ажиллагааны хуваарь, цаг хугацааг оновчтой тооцоолж, төлөвлөөгүй, тендер оройтож зарласан, гүйцэтгэгчийн буруутай байдлаас үүдэн гэрээний хугацаандаа төсөл хөтөлбөр хэрэгжилгүй ач холбогдол нь буурах;
- Зураг төсөв батлаагүй байхад тендерийг зарлах, ажлыг эхлэх зэрэг удирдлага, зохион байгуулалтын алдаа тогтмол гарч байна. Энэ мэтчилэн гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн алдаа дутагдалд зөвлөмж өгсөн ч арилахгүй давтан гарсаар байгаа нь гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг бууруулж байна.

Өөр нэгэн жишээ: Баянхонгор-Арвайхээр чиглэлийн авто замын огцом эргэлтийг өөрчилснөөр тухайн замд гарах зам тээврийн осол, зөрчлийн тоог бууруулах ач холбогдолтой боловч цаг хугацаандаа хийгдээгүй 56%-ийн гүйцэтгэлтэй байна. Мөн Туул зөрлөг орчмын төмөр замын доорх автомашины нүхэн гарц хийх ажил нь түгжрэлийг бууруулах чухал ач холбогдолтой ч зураг төсөв нь батлагдаагүй зэрэг аудитаар илэрсэн ч зөвлөмжийн

дагуу алдаа зөрчлийг арилгуулаагүй, дахин давтагдсан тохиолдлууд цөөнгүй байна.

Бид судалгааныхаа үр дүнд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх нэг гарц бол хяналтын механизмыг сайжруулах, тухайлбал гүйцэтгэлийн аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх явдал юм гэсэн шийдэлд хүрлээ.

Төрийн аудитын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх дараах арга замуудыг санал болгож байна. Үүнд:

- о Гүйцэтгэлийн аудитын журмын 8.8-д ... жил бүр, хоёр, гурав, дөрвөн жил тутамд нэг удаа хийх гэсэн заалтыг “төсөл, хөтөлбөрийн хугацаагаар хийх” гэж өөрчлөх шаардлагатай. Ингэснээр “Төрийн аудитын тухай” Монгол Улсын хуульд заасан гүйцэтгэлийн аудитын тодорхойлолтын агуулга хэрэгжинэ. Өнөөдрийн байдлаар төсөл, хөтөлбөрийг хэрэгжээд дууссаны дараа гүйцэтгэлийн аудит хийх явдал гарч байгаа бөгөөд аудитын мөрөөр зөрчлийг нэгэнт засварлах боломжгүй болсон байх явдал түгээмэл байгаа нь судалгаанаас харагдаж байсан.
- о Гүйцэтгэлийн аудитыг зөвхөн төгсгөлийн хяналт бус урьдчилсан хяналтын үүргээр хэрэгжүүлдэг байх нэн шаардлагатай. Учир нь, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл, төлөвлөлт, судалгаа тооцоолол зэрэг бичиг баримтуудыг урьдчилан хянаж, дүгнэлт гаргаж, түүний мөрөөр арга хэмжээ аваагүйгээс үүдэн тухайн төсөл хөтөлбөр анхнаасаа үр дүнгүй, үр ашиггүй болох, түүнчлэн зөрчил засагдахгүй хэд хэдэн он дамжин яригдсаар байх үзэгдэл нэлээд газар авсан байдаг нь харагдаж байна.
- о Гүйцэтгэлийн аудитад иргэд, олон нийтийн хяналтыг ашиглах, үүнтэй холбоотой харилцааг холбогдох журамд нарийвчлан тусгах шаардлагатай. Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг иргэд, хэрэглэгчид, олон нийтээр үнэлүүлэх, тогтолцоог бий болгох хэрэгтэй байна. Үнэлгээний үр дүн болон судалгааны мөрөөр авсан арга хэмжээг нийтэд ил тод, бодитоор мэдээлж байх, энэ харилцааг хуульчилж, дүрэм журмыг яаралтай боловсруулах нь зүйтэй.
- о Гүйцэтгэлийн аудитын мэргэжилтнүүдийг бэлтгэхэд онцгой анхаарах шаардлагатай байна. Аудиторуудын мэргэжлийн бэлтгэл, дадлага туршлагыг сайжруулаад зогсохгүй аудиторын мэргэжлийн сэтгэл зүй, төлөвшилтийн хувьд өндөр хэмжээнд бэлтгэхэд чиглэгдсэн тасралтгүй боловсролын тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй.
- о Гүйцэтгэлийн аудитын журмын 5.4-т аудитыг чанартай гэж үзэх нийтлэг шинж байдлыг тусгасан байдаг бөгөөд “Ач холбогдол, ашиг тустай байх зарчим” гэдэгт Аудитаар авч үзсэн асуудал ач холбогдолтой, тайлан нь шүүмжлэх байр сууринаас илүүтэйгээр засаж сайжруулах арга хандлагыг баримталсан, гүйцэтгэлийн аудитынхаа хувьд тохирох зөвлөмжүүдийг багтаасан байхыг ойлгоно хэмээн заасан байдаг. Энэ ойлголт нь нийгэмд, хэрэглэгчдэд бий болгох ач холбогдлыг тусгаагүй байна. Иймд энэ хэсэгт “нийгэмд бий болгосон ач холбогдлыг үнэлж, уг ач холбогдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой зөвлөмж боловсруулах” гэж нэмж оруулах хэрэгтэй.

о Гүйцэтгэлийн аудитын журмын 13-р зүйлд Аудитын мөрөөр хийх үйл ажиллагааг заасан байдаг боловч 13.6-д “Давтан аудитын үр өгөөж нь гарах зардлаас илүү байх магадлалтай нөхцөлд хийнэ” гэж заасан нь учир дутагдалтай байна. Үр өгөөжийг бодитоор мөнгөн дүнгээр үнэлж, зардалтай харьцуулан илүү үр өгөөжтэй гэж тодорхойлох нь хүндрэлтэй бөгөөд шууд субъектээс хамаарч байгаа юм. Гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг нэмэгдүүлэхэд аудитын мөрөөр хийх ажил чухал үүрэгтэй. Гэвч дээрх заалтаас үүдэн дахин шалгалт хийдэггүй тохиолдол нийтлэг байна. Иймд уг заалтыг хасаж “Давтан аудитыг илэрсэн алдаа зөрчлийн тоо, нийгэмд бий болох үр дүн, үр нөлөөтэй уялдуулан хийх бөгөөд, зардал, ач холбогдлыг харгалзан үзэж хамрах хүрээг тодорхойлно” хэмээн зааж өгөх нь зүйтэй.

Түүнчлэн Төрийн аудитын үр нөлөөг дээшлүүлэхэд аудитын байгууллага, харилцагч байгууллагын хамтын хүчин чармайлт чухал тул гүйцэтгэгч байгууллагын дотоод хяналт, дотоод аудитын ажлын зохион байгуулалт, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үр дүн, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх нь нийгэм, эдийн засгийн олон талын ач холбогдолтой. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн зүгээс тавьж буй хяналт бол гүйцэтгэлийн аудит юм. Гүйцэтгэлийн аудит нь манай практикт хэдийгээр шинэ тутам үүсч, хөгжиж байгаа боловч хууль эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн байна. Гэвч, ЗТХЯ-ны АЗБХГ-ын жишээн дээр төсөл хөтөлбөрийг хэрэглэгчдээр үнэлүүлэх судалгааны үр дүнгээс харахад төсөл хөтөлбөрүүдийн үр дүн хангалтгүй, үр ашгийн хувьд сайн биш, харин үр нөлөө харьцангуй сайн гэсэн судалгааны үр дүн гарлаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг хангалттай сайн биш байгаа нь олон хүчин зүйлээс шалтгаална, тэдгээрийн нэг нь гүйцэтгэлийн аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх явдал юм гэж дүгнэлээ

Энэхүү судалгааны ажлаар гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг дээшлүүлэх арга зам бол нэгдүгээрт, гүйцэтгэлийн аудитыг цаг хугацаа, орон зайн хувьд төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэх; хоёрдугаарт, аудитад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх гэсэн үндсэн саналууд болон холбогдох бусад саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материал

- Авирмэд, Б. (2013). *Аудитын чанарын хяналтыг сайжруулах арга замууд*.
- Агваан, Н. (2002). *Аудит*. Улаанбаатар.
- Агваан, Н. (2017). *Аудитын онол арга зүй ба Санхүүгийн аудит*. Улаанбаатар.
- Бурмаа, Н. (2017). *Аудитын хөгжлийн зарим асуудал*.
- Сэргэлэн, Б. (2014). *Төрийн аудитын чанарт хийсэн судалгаа* (Монгол улсын төрийн аудитын жишээн дээр).
- Оюунсүрэн, Т. (2016). *Төрийн аудитын үр нөлөөг дээшлүүлэх арга зам*.
- Энхтайван, Э. (2016). *Төрийн аудитыг үр дүнтэй хэрэгжүүлэх арга зам*.
- Аудитын тухай Монгол улсын хууль (1997)
- Гүйцэтгэлийн аудитын журам (2016)
- Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товч тайлан
- Төрийн аудитын тухай Монгол Улсын хууль (2003)
- Төсвийн тухай Монгол Улсын хууль (2011)
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, гүйцэтгэлийн аудитын тайлан (2013-2019)
- Үндэсний аудитын газрын үйл ажиллагааны тайлан (2017-2019)
- Зам тээврийн хөгжлийн яам, <https://www.mrtd.gov.mn>
- Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, <http://www.monicpa.mn>
- Сангийн яам, <https://mof.gov.mn>
- Үндэсний аудитын газар, <https://audit.mn>
- Шилэн данс, <https://shilendans.gov.mn>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://www.legalinfo.mn>